



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 283

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг  
сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 8 дугаар зүйлийн 8.2.1, 8.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гүйцэтгэх захирлын 2015 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 274 дүгээр тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан “Зэргэд ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг “Зэргэд ҮЦК” ХХК /Ш.Эрдэнэ/-нд анхааруулсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АНГАР